



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/04-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Отгонбаяр

Утас: 70363047

Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт.....	2-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12-13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13-14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	14-15
3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15-18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/04-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Г СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН Г
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
Б. ДАРИХЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 124.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн .
- Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр нягтлан бодогч Байгалмаад 2020 оны төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 350.3 мянган төгрөгийг тайлант оны батлагдсан төсвөөс олгосон.

- Бүтэц, орон тоонд батлагдаагүй мэдээлэл технологи, хөдөлмөр аюулгүй байдал, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг 3 албан хаагчаар хавсруулан гүйцэтгүүлсэн гэх үндэслэлээр 4,612.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, 7 сарын хугацаанд гэрээт ажилтан ажиллуулж, 2,940.0 мянган төгрөгийн цалинг үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олгосон.
- Тус албаны дарга Б. Дарихжав нь өмнөх оны тайланд тусгагдсан өөрийнх нь /Б. Дарихжавын / цалингийн урьдчилгааны өр 1,020.0 мянган төгрөг болон тайлант онд өөртөө 688.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин бодож, батлагдсан цалингийн төсвөөс тооцон 1,708.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер нийлүүлсэн.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр тус албаны дарга Б. Дарихжав нь өөртөө 556.9 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр 157.2 мянган төгрөгийн цалин, 78.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор зэрэг нийт 792.7 мянган төгрөгийг илүү болон давхардуулан олгосон байна

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна" гэсэн заалтууд болон аймгийн Засаг даргын 2014 оны А/433 дугаар захирамжаар батлагдсан Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2, 2.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Тасалбар болголт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,528,000.00	2,752,474.21
33	АВЛАГА	1,020,000.00	124,474.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,020,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,508,000.00	2,628,000.00
35400	Хангамжийн материал	2,508,000.00	2,628,000.00
35420	Аж ахуйн материал	863,000.00	863,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,645,000.00	1,765,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,031,208.18	13,814,828.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,031,208.18	13,814,828.88
39200	Биет хөрөнгө	14,510,541.52	13,470,162.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,221,700.00	16,158,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,616,145.32	-9,505,944.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,775,600.00	10,775,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,870,613.16	-3,957,493.18
39300	Биет бус хөрөнгө	520,666.66	344,666.62
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-359,333.34	-535,333.38
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,559,208.18	16,567,303.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,400,000.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,400,000.00	0.00
41300	Өглөг	2,400,000.00	0.00
41360	Бусад өглөг	2,400,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,400,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,159,208.18	16,567,303.09
51	Засгийн газрын хувь оролцоо	16,159,208.18	16,567,303.09
51200	Хуримтлагдсан үр дүн	16,159,208.18	16,567,303.09
51210	Өмнөх үеийн үр дүн	17,440,032.72	16,159,208.18
51220	Тайлант үеийн үр дүн	-1,280,824.54	408,094.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,559,208.18	16,567,303.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	115,953,691.43	132,172,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,953,691.43	132,172,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,953,691.43	132,172,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,953,691.43	132,172,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	117,234,515.97	131,764,705.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,234,515.97	131,764,705.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,634,515.97	130,764,705.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	81,589,270.67	88,557,781.48
210101	Үндсэн цалин	65,896,229.81	67,713,620.89

210102	Нэмэгдэл	13,061,440.86	16,716,160.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,631,600.00	4,128,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,960,250.76	12,010,244.31
210201	Тэтгэврийн даатгал	6,297,255.67	8,458,100.32
210202	Тэтгэмжийн даатгал	915,923.78	1,047,115.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,739.01	668,007.60
210204	Ажилгүйдлийн даатгал	183,184.74	166,997.30
210205	Эрүүл мэндийн даатгал	1,831,147.56	1,670,023.82
2104	Хангамж, бараа материалын зардал	9,665,600.00	12,730,000.00
210401	Бичиг хэрэг	2,107,200.00	3,176,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,300,000.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,714,400.00	2,800,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	1,230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,600.00	2,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	496,600.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,283,300.00	5,988,300.00
210702	Дотоод албан томилолт	7,283,300.00	5,988,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	590,000.00	750,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,049,494.54	8,228,379.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	693,000.00	600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,356,494.54	7,628,379.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,280,824.54	408,094.91
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,280,824.54	408,094.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	115,953,691.43	132,172,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,953,691.43	132,172,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,953,691.43	132,172,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,953,691.43	132,172,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,453,691.43	129,922,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,453,691.43	129,922,800.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,853,691.43	128,922,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,369,707.31	89,698,800.00
210101	Үндсэн цалин	61,978,472.34	62,972,300.00
210102	Нэмэгдэл	18,484,734.97	22,404,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,906,500.00	4,322,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,176,584.12	11,735,700.00
210201	Тэтгэврийн даатгал	6,513,589.03	8,117,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	915,923.78	906,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,739.01	722,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	183,184.74	181,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,831,147.56	1,807,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,621,600.00	14,450,000.00
210401	Бичиг хэрэг	2,107,200.00	3,176,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,300,000.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,714,400.00	2,800,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	2,950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,700,000.00
210602	Тавилга	0.00	800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	0.00	2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,283,300.00	5,988,300.00
210702	Дотоод албан томилолт	7,283,300.00	5,988,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	709,500.00	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	493,500.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	693,000.00	600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	693,000.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,500,000.00	2,250,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,500,000.00	2,250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,500,000.00	2,250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,500,000.00	2,250,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,500,000.00	2,250,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,500,000.00	-2,250,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	17,440,032.72	17,440,032.72
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	17,440,032.72	17,440,032.72
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,280,824.54	-1,280,824.54
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	16,159,208.18	16,159,208.18
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	16,159,208.18	16,159,208.18
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	16,159,208.18	16,159,208.18
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	408,094.91	408,094.91
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	16,567,303.09	16,567,303.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,388,800.00	132,172,800.00	216,000.00	99.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,388,800.00	132,172,800.00	216,000.00	99.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,388,800.00	131,172,800.00	216,000.00	99.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,698,800.00	89,698,800.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	62,972,300.00	62,972,300.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	22,404,500.00	22,404,500.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,322,000.00	4,322,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,735,700.00	11,735,700.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	8,117,400.00	8,117,400.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	906,500.00	906,500.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	722,500.00	722,500.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,700.00	181,700.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,807,600.00	1,807,600.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,450,000.00	14,450,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	3,200,000.00	3,176,000.00	24,000.00	99.25
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,800,000.00	0.00	100.00

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,950,000.00	2,950,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,950,000.00	7,950,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,250,000.00	2,250,000.00	0.00	100.00
210602	Тавилга	800,000.00	800,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,400,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,988,300.00	5,988,300.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	5,988,300.00	5,988,300.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	966,000.00	750,000.00	216,000.00	77.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	0	216,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	750,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	600,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,388,800.00	132,172,800.00	216,000.00	99.84
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	132,388,800.00	132,172,800.00	216,000.00	99.84
320001	Орон нутгийн төсвөөс	132,388,800.00	132,172,800.00	216,000.00	99.84
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	7	-1	116.67
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5	4	1	80.00
620003	Үйлчлэх ажилтан	0	1	-1	
620004	Гэрээт ажилтан	0	1	-1	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба /цаашид Санхүүгийн хяналт, аудитын алба гэх/-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх, олгосон цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд бүрэн тайлагнаж байх, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог эрх бүхий албан тушаалтнаар хянуулж баталгаажуулсны дараа олгож байх гэсэн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Санхүүгийн хяналт, аудитын алба нь “Аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд системтэй, оновчтой арга хандлагаар санхүүгийн хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлэх замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хараат бус бодитой дүгнэлт гарган аймгийн удирдлагын засаглалын эрсдэлийг бууруулах, төсөв санхүүгийн сахилга батыг сахиулах, төсвийн хөрөнгийн зохистой бүрдүүлэлт, зарцуулалт үр ашигтай байдлыг бий болгох.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж үзэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар тушаалаар баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.


Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 117,234.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,758.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1,318.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,991.9 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,020.00	124.50	(895.50)
Урьдчилгаа			
Бараа материал	2,508.00	2,628.00	120.00
Үндсэн хөрөнгө	15,031.20	13,814.80	(1,216.40)
Нийт хөрөнгө	18,559.20	16,567.30	(1,991.90)
Өр төлбөр	2,400.00		(2,400.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,159.20	16,567.30	408.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,559.20	16,567.30	(1,991.90)

Авлага дансны үлдэгдэл 895.5 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 1,020.0 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд НДШ-ийн 124.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,628.0 мянган төгрөг болж 120.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,456.0 мянган төгрөгийн материал худалдан авч, 15,336.0 мянган төгрөгийн материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд он дамжсан, ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 27,813.6 мянган төгрөг болж 8,063.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 2,250.0 мянган төгрөгийн компьютер, принтер худалдан авсан болон бусад эх үүсвэрээр 1,708.0 мянган төгрөгийн компьютер, принтер хүлээн авч, аймгийн ИТХТ-ийн 2021 оны 43 дугаар тогтоолоор 12,021.7 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалсан байна.

2020 оны эцэст 800.0 мянган төгрөгийн ширээ, сандал, 1,600.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг зээлээр авч нийт 2,400.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнийг тайлант онд барагдуулж, оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,567.3 мянган төгрөг болж, 408.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,219.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 14,530.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 9,018.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,064.4 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлыг 2,003.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 443.7 мянган төгрөгөөр тус тус нэмж баталсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 180,173.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 47,784.3 мянган төгрөгөөр бууруулж, 132,388.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, томилолтын зардлыг 15,129.8 мянган төгрөгөөр бууруулж, хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг 15,129.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, баталснаас шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 132,388.8 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 132,172.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, аудит баталгаажуулалт зардал 216.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжилтийн дүнгээс бууруулсан тул үндсэн үйл ажиллагаанд 132,172.8 мянган төгрөгийн зардлыг зарцуулж, бичиг хэргийн зардлаас ном хэвлэлийн зардалд 24.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулснаас бусад зардлын гүйцэтгэлд хэтрэлт, хэмнэлт гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130051416 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцлох ажил гүйлгээ, асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 124.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн .
- Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр нягтлан бодогч Байгалмаад 2020 оны төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 350.3 мянган төгрөгийг тайлант оны батлагдсан төсвөөс олгосон.
- Бүтэц, орон тоонд батлагдаагүй мэдээлэл технологи, хөдөлмөр аюулгүй байдал, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг 3 албан хаагчаар хавсруулан гүйцэтгүүлсэн гэх үндэслэлээр 4,612.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, 7 сарын хугацаанд гэрээт ажилтан ажиллуулж, 2,940.0 мянган төгрөгийн цалинг үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олгосон.
- Тус албаны дарга Б.Дарихжав нь өмнөх оны тайланд тусгагдсан цалингийн урьдчилгааны өр 1,020.0 мянган төгрөг болон тайлант онд өөртөө 688.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин бодож, батлагдсан цалингийн төсвөөс тооцон 1,708.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер нийлүүлсэн.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр тус албаны дарга Б. Дарихжав нь өөртөө 556.9 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр 157.2 мянган төгрөгийн цалин, 78.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор зэрэг нийт 792.7 мянган төгрөгийг илүү болон давхардуулан олгосон байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 119 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тус албаны тайлант оны үйл ажиллагаанд 132,388.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 132,172.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.2 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,020.0 мянган төгрөгийн суутгагдаагүй цалингийн урьдчилгааг тайлант оны цалингаас нөхөн суутгах албан шаардлага өгсөн бөгөөд уг авлагыг цалингаас суутгалгүйгээр зөөврийн компьютер, принтер нийлүүлсэн байна. Харин алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг биелүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,654.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 792.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,735.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 12,126.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр тус албаны дарга Б. Дарихжав нь өөртөө 556.9 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр 157.2 мянган төгрөгийн цалин, 78.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор зэрэг нийт 792.7 мянган төгрөгийг илүү болон давхардуулан олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх *“Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2: *“Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал*

олгоно; 1.2.1-д **“Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн ... урамшуулал авах нөхцөлийг хангасан ... төсвийн шууд захирагчид”** гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн **“Нийцсэн бөгөөд зохистой байх”** батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр илүү болон давхардуулан олгосон урамшуулал, ээлжийн амралтын олговрыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага :

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд 124.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь **“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”**, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь **“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”** гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн **“Нийцсэн бөгөөд зохистой байх”** батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог хянан баталгаажуулах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр нягтлан бодогч Л.Байгалмаад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 350.3 мянган төгрөгийг тайлант оны батлагдсан төсвөөс олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх **“Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”**, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх **“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”**, 14.4.3 дахь **“бүх өр төлбөр”** гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн **“Тасалбар болголт”**, **“Нийцсэн бөгөөд зохистой байх”** батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Бүтэц, орон тоонд батлагдаагүй мэдээлэл технологи, хөдөлмөр аюулгүй байдал, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг 3 албан хаагчаар хавсруулан гүйцэтгүүлсэн гэх үндэслэлээр 4,612.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, 7 сарын хугацаанд гэрээт ажилтан ажиллуулж, 2,940.0 мянган төгрөгийн цалинг үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь **“ Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”**, аймгийн Засаг даргын 2014 оны А/433 дугаар захирамжаар батлагдсан Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2-т **“Санхүүгийн хяналт, аудитын алба нь аудитын албаны дарга санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор, санхүүгийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодогч, архив-бичиг хэргийн ажилтан, жолооч гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулна”**, 2.4-д **“Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нь аудитын албаны батлагдсан**

бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажилтнуудыг ... томилж, чөлөөлөх” гэсэн заалтуудтай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Тус албаны дарга Б.Дарихжав нь өмнөх оны тайланд тусгагдсан цалингийн урьдчилгааны өр 1,020.0 мянган төгрөг болон тайлант онд өөртөө 688.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин бодож, батлагдсан цалингийн төсвөөс тооцон 1,708.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер нийлүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5. Албаны дарга Б. Дарихжав нь өмнөх аудитаар өөрийнх нь / Б.Дарихжавын / цалингийн урьдчилгааны өрийг 2021 оны цалингаас нөхөн суутгах албан шаардлага өгсөн боловч цалингаас суутгал хийлгүйгээр зөөврийн компьютер, принтер нийлүүлсэн, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөрөө өөртөө цалин, урамшуулал, ээлжийн амралтын олговрыг давхардуулан болон илүү олгосон, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, орон тоог хэтрүүлсэн зэргээр албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэн, материаллаг хэмжээний зөрчил гаргасан тус албаны дарга Б. Дарихжавт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 10,400.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн

дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Цалинтай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд гэрээт ажилтнаар ажиллаж байсан Т.Соёлтуяагийн 5, 6-р сарын 1,002.0 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг бүрэн тайлагнаж байх.

1.2.1 Илрүүлэлт: Тус албаны дарга Б.Дарихжавын илүү ажилласан цагийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулаагүй байхад 724.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-д “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог эрх бүхий албан тушаалтнаар хянуулж баталгаажуулсны дараа олгож байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн хяналт, аудитын алба	9	22,654.9			1	792.7	5	9,735.6	3	12,126.6